



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

“Өгөөмөр Уул” ХК-ийн нэгдмэл сонирхолтой  
хувьцаа эзэмшигчдээс Компанийн тухай хуулийн

57.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, хувьцааг худалдан авах саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Өгөөмөр Уул” ХК-ийн нийт гаргасан 57,835 ширхэг хувьцааны 54.6 хувь буюу 31,553 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох иргэн Ц.Ганболд иргэн Б.Петр нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 45.4 хувь буюу 26,282 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 128 /нэг зуун хорин найм/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2014 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Өгөөмөр Уул” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд / Ц.Ганболд /-д үүрэг болгосугай.

1/ Компанийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодексыг”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000114